



Европын Холбоо
санхүүжүүлэв



Food and Agriculture
Organization of the
United Nations



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



U
N
D
P

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТой УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД
ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН
ШИНЖИЛГЭЭ



Улаанбаатар хот
2024 он

ЕВРОПЫН ХОЛБООНЫ САНХҮҮЖИЛТТЭЙ “МОНГОЛ УЛСАД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨР ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ШИНЭЧЛЭЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Тайланг боловсруулсан:

А.Мөнх-Оргил, НҮБХХ-ийн зөвлөх

Г.Түвшинтуяа, НҮБХХ-ийн зөвлөх

Хянан тохиолдуулсан:

Н.Мөнхсүх, Сангийн яамны Төрийн сангийн газрын, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга

Энэхүү “Монгол Улсын 2023 оны хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайлангийн шинжилгээ” судалгааны тайланг “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд боловсруулав. Төслийг Европын Холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлдэг.

НҮБХХ нь ядуурал, тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шударга бус байдлыг эцэслэх зорилго бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага юм. Дэлхийн 170 орны түншлэгчид болон мэргэжилтнүүдийн өргөн цар хүрээт хамтын ажиллагааны дүнд эх дэлхий, хүн бүрийн сайн сайхны төлөө хөгжлийн урт хугацааны, цогц шийдлийг бий болгоход улс үндэстнүүдийг дэмжин ажилладаг.

Европын Холбоо бол Европ тивийн 27 тусгаар улсын эдийн засаг, улс төрийн нэгдэл юм. Тус Холбоо нь хүний эрхэм чанар, эрх чөлөө, ардчилал, эрх тэгш байдал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг түүний дотор цөөнхийн эрхийг дээдлэх үндсэн үнэт зүйлс дээр тулгуурлан байгуулагджээ. Өнөө цагт Европын Холбоо нь даян дэлхийн хүн бүрд хүртээмжтэй, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа явуулж байна.

Ерөнхий мэдэгдэл

Тайлангийн агуулга зөвхөн зохиогчдын үзэл бодлыг илэрхийлж байгаа бөгөөд Европын Холбоо болон НҮБХХ-ийн албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй. Энэхүү тайланд ашигласан мэдээллийн үнэн зөв эсэх, тухайн материалыг ашигласны улмаас гарах үр дагаварт Европын Холбоо, НҮБХХ хариуцлага хүлээхгүй болно. НҮБХХ-ийн зөвшөөрөлгүйгээр энэхүү хэвлэлийг худалдах, эсвэл ямар нэгэн ашиг олох хэрэгсэл болгохыг хориглоно.

ISBN: 978-9919-9195-3-5

АГУУЛГА

УДИРТГАЛ	4
МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	5
УЛСЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	7
Хөтөлбөр.....	9
Хөтөлбөрийн хүрэх үр дүн.....	9
Хөтөлбөрийн төсөв, гүйцэтгэл	10
Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	12
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	14
Хөтөлбөр.....	16
Хөтөлбөрийн хүрэх үр дүн.....	17
Хөтөлбөрийн төсөв, гүйцэтгэл	18
Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт	20
Санал, зөвлөмж	22
Хавсралт	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрэх үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт (улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч багтсан байдлаар).....	6
Хүснэгт 2 Улсын төсвийн шалгуур үзүүлэлтийн шинжилгээ	10

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт ..	8
Зураг 2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо.....	9
Зураг 3 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо	9
Зураг 4 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /тэрбум төгрөгөөр/	10
Зураг 5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /хөтөлбөрөөр, тэрбум төгрөгөөр/	11
Зураг 6 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт.....	15
Зураг 7 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо	16
Зураг 8 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо	17
Зураг 9 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /аймгаар, тэрбум төгрөгөөр/	19
Зураг 10 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /хөтөлбөрөөр, сая төгрөгөөр/.....	20

УДИРТГАЛ

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) нь “Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” техникийн туслалцааны төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлж байна. Сангийн яам нь энэхүү төслийг НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж байна.

Төслийн дэмжлэгийн хүрээнд Монгол Улсад бодлого ба төсвийн уялдааг хангах, үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг ТХЗ-ийн тэргүүлэх салбар, хөтөлбөрүүдэд нэвтрүүлэх, дунд хугацааны зарлагын хүрээнд шилжих бодлогын хувилбарыг тодорхойлох болон түүний тайлагнал, хяналт шинжилгээ хийх арга зүйг бий болгох, хувилбарыг турших зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Төслийн “Тайлагнал” хариуцсан бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Монгол Улсын 2023 оны улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайланг нэгтгэн боловсрууллаа. Түүнчлэн туршилтын гурван төсвийн ерөнхийлөн захирагч болох ХХААХҮЯ, НХХЯ, ЭМЯ-ны хөтөлбөрийн үр дүнгийн өөрчлөлт, шалгуур үзүүлэлтийн дэлгэрэнгүй тайлан, тайлант онд улсын хэмжээнд батлагдсан шалгуур үзүүлэлтийн тодорхойлолтод нарийвчилсан шинжилгээ хийн тус тайланг боловсрууллаа.

Тус тайлан нь улсын хэмжээнд бүх төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөр, түүний үр дүн, зарцуулсан төсөв болон шалгуур үзүүлэлтийн уялдааг судалснаараа анхны бөгөөд суурь мэдээлэл болох ач холбогдолтой тайлан болсон. Мөн хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг төлөвлөлт, төсөвлөлтийн түвшинд тодорхойлох, тайлагнах эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд бодит үнэлгээ өгөх боломжийг бүрдүүлсэн.

БҮРЭЛДЭХҮҮН. НЭГ

МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв хүрсэн үр дүнгийн тайланг тайлагнах эрх зүйн актыг 2023 оны 12 дугаар сард Сангийн сайдын 225 тоот тушаалаар батлуулсан билээ. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж улсын хэмжээнд анх удаа батлагдсан төсвөө үр дүнтэйгээ уялдуулан үр ашгаа тайлагнаж байгаа энэ удаагийн тайлангийн онцлог болж байна. Монгол Улсын 2023 оны төсвийн жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн”-ийн тайланд улсын төсвийн 38, орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүнгийн тайланг холбогдох журмын дагуу нэгтгэсэн¹. Үүнд нийт 538² хөтөлбөрийн үр дүнг нэгтгэсэн бөгөөд үүнээс 82 хөтөлбөрийн 97 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 359 хөтөлбөрийн 478 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 97 хөтөлбөрийн 127 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй буюу нийт батлагдсан хөтөлбөрийн 85 хувь нь буюу 456 хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна.

Зарцуулсан төсөв болон хөтөлбөрийн гүйцэтгэлээр 85%-аас бага үр дүнтэй хөтөлбөрийн дундаж үр ашиг нь -26% буюу үр ашиггүй, 85%-100%-ийн гүйцэтгэлтэй хөтөлбөрийн дундаж үр ашиг 5% бол 100%-ээс дээш үр дүнтэй хөтөлбөрүүд 87%-ийн үр ашигтай байна. Хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлийн хэмжээ төсвийн үр ашигт уялдахдаа гүйцэтгэлтэй 85 болон түүнээс дээш хувьтай хэрэгжсэн тохиолдолд хөтөлбөрийн төлөвлөсөн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, үр ашгийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Монгол Улсын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрэх үр дүнгийн тайлангийн тоон үзүүлэлт (улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч багтсан байдлаар)

Нэгтгэл								
Хөтөлбөрийн /хувиар/	гүйцэтгэл	Батлагдсан төсөв /тэрбум төгрөгөөр/	Төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/	Гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Үр ашиг
100%-ээс дээш		930.1	898.2	92%	97	127	246	87%
85%-100%		845.6	794.7	93%	359	478	565	5%
85%-аас бага		443.8	347.2	76%	82	97	117	-26%
НИЙТ		2,219.5	2,040.1	87%	538	702	928	33%
Улсын төсөв								
Хөтөлбөрийн /хувиар/	гүйцэтгэл	Батлагдсан төсөв /тэрбум төгрөгөөр/	Төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/	Гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо
100%-ээс дээш		882.2	856.8	97%	45	68	164	131%
85%-100%		500.5	492.8	98%	32	50	94	3%
85%-аас бага		312.8	256.9	82%	19	31	42	-45%
НИЙТ		1,695.5	1,606.5	93%	96	149	300	55%
Орон нутгийн төсөв								
Хөтөлбөрийн /хувиар/	гүйцэтгэл	Батлагдсан төсөв /тэрбум төгрөгөөр/	Төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөгөөр/	Гүйцэтгэлийн хувь	Хөтөлбөрийн тоо	Хүрэх үр дүнгийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Шалгуур үзүүлэлтийн тоо
100%-ээс дээш		47.8	41.4	87%	52	59	82	43%
85%-100%		345.2	301.9	87%	327	428	471	8%
85%-аас бага		131.0	90.3	69%	63	66	75	-6%
НИЙТ		524.0	433.6	81%	442	553	628	10%

¹ Сангийн сайдын 2023 оны 225 дугаар тушаал. “Маягт аргачлал батлах тухай”


² Давхардсан тоогоор

БҮРЭЛДЭХҮҮН. ХОЁР

**УЛСЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД
ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”³ дагуу 38 төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 96 хөтөлбөр, 149 хөтөлбөрийн үр дүнд нийт 300 хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг баталсан.


Тайлант хугацаанд 19 хөтөлбөрийн 31 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 32 хөтөлбөрийн 50 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 45 хөтөлбөрийн 68 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй байна.



Зураг 1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт

³ Монгол улсын төсвийн 2023 оны төсвийн тухай хууль. Нэгдүгээр хавсралт. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

ХӨТӨЛБӨР




Зураг 2 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо

Улсын төсвийн 38 ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт нийт 98 хөтөлбөр батлагдсанаас давхардаагүй тоогоор 91 хөтөлбөрт хуваарилагдсан байна. Үүнээс нийт 21 төсвийн ерөнхийлөн захирагч буюу 55 хувь нь нэг хөтөлбөртэй бол хамгийн олон хөтөлбөртэй төсвийн ерөнхийлөн захирагч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд 12 хөтөлбөртэй байна.

Тус хөтөлбөр нь төрийн сангийн бүртгэлийн хөтөлбөртэй ижил бөгөөд төсвийн жилийн дундуур төсөвт нэмэлт өөрчлөлт оруулснаар 5 төсвийн ерөнхийлөн захирагч дээр 6 хөтөлбөр нь төсвийн хавсралтад батлагдаагүй бөгөөд үр дүнгүй, гүйцэтгэл гарсан байна. Энэ нь төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах үед төсвийн хөтөлбөр, үр дүнгийн хавсралт хамт шинэчлэгдэхгүй байгаатай холбоотой байна.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН



Зураг 3 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо

Улсын төсвийн 38 ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт нийт 139 хөтөлбөрийн хүрэх үр дүн батлагдсан. Нийт төсвийн ерөнхийлөн захирагчийн 26 нь буюу 68 хувь нь 1-3 хөтөлбөрийн үр дүнтэй байна. Хамгийн олон хөтөлбөрийн үр дүнтэй төсвийн ерөнхийлөн захирагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрөөс 4 хөтөлбөр тус бүр хоёр хүрэх үр дүнтэй бөгөөд бусад хөтөлбөр нь тус бүр нэг хөтөлбөртэй байна. Үүнд Монгол Улсын 2023 оны төсөвт батлагдаагүй хөтөлбөрийн хувьд хөтөлбөрийн үр дүнгүй нэгтгэгдсэн.

Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжийн дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүнд тавьсан шаардлагын хүрээнд нийт жилийн эцсийн тайлангийн хүрээнд судалж үзлээ.

Хүрэх үр дүнг “Тухайн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн өөрчлөлтийг хэмжиж болохуйц үр дүн байдлаар бичнэ. Нэг

хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн үр дүнд хүрэхээр тодорхойлж болно” гэж заасан бөгөөд тодорхойлох хүрээнд⁴:

1. Салбарын эсвэл эрхлэх ажлын хүрээнд тулгарч байгаа асуудлыг шийдэх стратегийн зорилтыг агуулах, товч тодорхой, нэг утгыг илэрхийлэх;
2. Тодорхой шийдвэр гаргахад чухал мэдээллийг илэрхийлэх;
3. Гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч ажилтан, албан хаагч тус үзүүлэлтийг тодорхойлоход оролцсон байх, тэдний саналыг тусгах;

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. ТМ-01а маягт бөглөх заавар. Эх сурвалж: Сангийн яам www.mof.gov.mn

4. Зөвхөн ач холбогдолтой гол үр дүнг тодорхойлох (зөвхөн хэмжиж болох үзүүлэлтүүд, хийх ажил эсвэл процессыг тоочихгүй байх) зэрэг шаардлагыг тавьсан бөгөөд үүнийг хөтөлбөр тус бүрийн хүрээнд нарийвчилсан судалгаа хийж дүгнэлт хийх шаардлагатай юм. Хүрэх үр дүнг тодорхойлох талаар дараах 4 үндсэн зарчим баримтлахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөмж болгосон бөгөөд тус зөвлөмжийн хүрээнд нийт 139 хөтөлбөрийг дараах байдлаар үнэллээ.


Хүснэгт 2 Улсын төсвийн шалгуур үзүүлэлтийн шинжилгээ

Зарчим	Хангасан	Эзлэх хувь
Хаана хэрэгжих (байршил)	32	23%
өөрчлөлтийг хэн хүртэх (үр шим хүртэгч, оролцогч тал)	43	31%
юуг өөрчлөхөөр зорьж байгааг,	137	99%
хүлээгдэж буй өөрчлөлтийн чиглэл (нэмэгдүүлэх/бууруулах)	72	52%

Нийт 139 үзүүлэлтийн шаардлагыг хангасан эсэхийг тооцоход “юуг өөрчлөхөөр зорьсон” үзүүлэлт хангалттай хангагдсан буюу 99 хувь байна. Энэ нь хөтөлбөрийн үр дүнд тухайн хөтөлбөрийг гол хэмжих зүйл болон хүчин зүйлийг дурдсан тул шаардлага хангаж байна. Харин бусад үзүүлэлтүүд хангалтгүй байгаа бөгөөд “товч тодорхой” байх зарчим ч мөн хангагдахгүй байна. Иймд цаашид хөтөлбөрийн үр дүнг төлөвлөхдөө удирдамжийн зарчим, шаардлагыг хатуу мөрдөх, түүнийг хянаж шалгаж, нэгтгэх шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2023 оны батлагдсан төсвийн дагуу улсын төсвийн нийт 38 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад нийт 16.5 их наяд төгрөг батлагдсан бөгөөд жилийн эцэст 16.0 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 93 хувийн гүйцэтгэлтэй санхүүжсэн байна.




Зураг 4 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /тэрбум төгрөгөөр/

Хамгийн их төсөвтэй 5 хөтөлбөр

Хөтөлбөрийн нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,008.6	1,008.2	100%
Ерөнхий боловсрол	1,444.1	1,436.2	99%
Сангийн яаман дээр батлагдсан төсөл хөтөлбөрүүд	1,795.0	1,539.3	86%
Санхүү, төсөв, эдийн засгийн нэгдсэн удирдлага	1,846.4	1,883.8	102%
Нийгмийн халамж	2,249.1	2,157.9	96%

Төсвийн гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр судалж үзэхэд 100 хувийн санхүүжилттэй буюу зарцуулсан хөрөнгийг бүрэн зарцуулсан 4 төсвийн ерөнхийлөн захирагч байгаа бол барилга, хот байгуулалтын сайдын багц батлагдсан төсвөөс хэтэрсэн байна. Нийт 38 төсвийн ерөнхийлөн захирагчаас 21 төсвийн ерөнхийлөгчийн багц улсын дундаж 93 хувьтай тэнцүү буюу илүү гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. Энэ нь

цаашид эдгээр төсвийн хөтөлбөрүүдийн үр дүнтэй болон үр ашигтай хэрэгжсэн байх нөхцөлийг бүрдүүлэх юм.




Зураг 5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /хөтөлбөрөөр, тэрбум төгрөгөөр/

Нийт 91 хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлээр ангилж үзэхэд 25 хөтөлбөр буюу 27 хувь нь 100 хувь болон түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр бүрэн санхүүжиж хэрэгжсэн хөтөлбөрт оногдох нийт төсвийн гүйцэтгэл нь 5.0 их наяд буюу нийт төсвийн 31 хувь оногдож байна. Гүйцэтгэл багатай буюу 50 хувиас бага гүйцэтгэлтэй 2 хөтөлбөр⁵, 80 хувиас бага гүйцэтгэлтэй 14 хөтөлбөр байна. Бага гүйцэтгэлтэй 14 хөтөлбөрт ногдох төсвийн гүйцэтгэл нь 1.0 их наяд буюу 6 хувь байна. Нийт 91 хөтөлбөрөөс хамгийн 1.0 их наяд болон түүнээс дээш төсөвтэй 5 хөтөлбөр байгаа бөгөөд эдгээр хөтөлбөрт нийт 8.3 их наяд буюу нийт төсвийн 50 хувь оногдох бол хамгийн бага төсөвтэй 1 тэрбум төгрөгөөс доош төсөвтэй 4 хөтөлбөр байна.

⁵ Хөнгө үйлдвэрийг хөгжүүлэх болон Агаар орчныг бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр


ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Улсын төсвийн нийт 38 төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрт нийт 300 шалгуур үзүүлэлт батлагдсан.





Төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 3 шалгуур үзүүлэлттэй ба 10 болон түүнээс дээш шалгуур үзүүлэлттэй 10 төсвийн ерөнхийлөн захирагч байна. Шалгуур үзүүлэлтийн тоо хөтөлбөр болон хүрэх үр дүнгийн тоо болон төсвийн хэмжээтэй хамааралтай. Хамгийн олон үр дүнгийн шалгуур үзүүлэлттэй төсвийн ерөнхийлөн захирагч нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
2. Боловсролын сайд
3. Хууль зүйн сайд байна.



Нийт 300 шалгуур үзүүлэлтийн 187 нь буюу 62 хувь нь чанарын, 113 нь тоон шалгуур үзүүлэлт батлагдсан байна. Харин нийт шалгуур үзүүлэлтийн 95 хувь буюу 286 нь өсөх хандлагатай төлөвлөгдсөн.



Монгол Улсын 2023 оны төсвийн төслийн удирдамжид⁶ заасны дагуу үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг “төсвийн хөтөлбөрийн үр дүнг хоёроос доошгүй, таваас ихгүй тоон эсвэл чанарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хэмжинэ” гэж заасан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 90 хөтөлбөрийг харьцуулахад нийт 61 хөтөлбөр 2-5 үр дүнгийн шалгуур үзүүлэлтэй батлагдаж шаардлага хангасан байгаа бол 14 хөтөлбөр 1 шалгуур үзүүлэлттэй, 10 хөтөлбөр 6-аас дээш шалгуур үзүүлэлттэй байна.

⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. ТМ-01а маягт бөглөх заавар. Эх сурвалж: Сангийн яам www.mof.gov.mn

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. ТМ-01а маягт бөглөх зааврын хэсгээс

Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь тодорхой (S), хэмжигдэхүйц (M), биелэхүйц (A), ач холбогдолтой (R) бөгөөд хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхой тусгасан (T) буюу SMART шинж чанарыг агуулсан байна. Хөтөлбөрийн хүрэх үр дүнг тодорхойлсон өгүүлбэрээс шалгуур үзүүлэлт нь тодорхой (S), хэмжигдэхүйц (M) болон цаг хугацаатай (T) байх шинж чанарыг шууд харах боломжтой бол, суурь болон зорилтот түвшинг тодорхойлсноор биелэхүйц (A) байх шинж чанарыг тус тус харах боломжтой. Тулгамдаж буй асуудлын шийдлийг дэвшүүлснээр ач холбогдолтой (R) эсэхийг тухайн хэрэгжүүлэгч өөрөө үнэлнэ. Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт нь (i) гол үзүүлэлт, (ii) юуг хэмжих, (iii) ямар нэгжээр хэмжихийг илэрхийлэн бичих бөгөөд, суурь он, түвшин бол зорилтот түвшний мэдээллийг баталгаажуулах мэдээллийн эх сурвалжийг зааж өгнө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг SMART шинж чанараар үнэлгээ өгөх нь хүндрэлтэй бөгөөд судлаачийн үзэл бодол хэт нөлөөлөх юм. Бүх үзүүлэлт юуг, хэрхэн хэмжих нь тодорхой мөн тухайн хөтөлбөрт улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжилт батлагдсан нь шалгуур үзүүлэлтийг биелэгдэхүйц болгож байна. Ач холбогдлын хувьд улсын төсөвт баталж байгаа нь тухайн хөтөлбөр болон шалгуур үзүүлэлтийг ач холбогдолтой болгож байна. Иймд цаашид анхаарах шаардлагатай байдлаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт түгээмэл гарч байгаа зарим асуудлыг доор дурдав.


Улсын төсвийн хөтөлбөр, арга хэмжээний тайлан нэгтгэхэд гарсан зарим хүндрэлийн жишээнээс:

1. **Ерөнхий сайд:** Тагнуул, нууцын байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл Төсвийн хуулийн хавсралтаар батлагддаггүй ч тухайн ТЕЗ-ын төсөв, гүйцэтгэл дээр нэмж гардаг. Мөн зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийг 3 үзүүлэлтийг өгүүлбэрээр хамтад нь баталсан. Жнь: Яам-16, аймаг-21, нийслэл, дүүрэг-10
 2. **ХЭҮК:** Шалгуур үзүүлэлтийн 1 зорилтот түвшинд 2 өөр мэдээлэл хамтад нь баталсан. Мөн тоон болон хувиар биш өгүүлбэрээр баталсан нь хүрсэн түвшний гүйцэтгэлийг гаргахад хүндрэлтэй. Жнь: Ирсэн өргөдөл, гомдлын 95%-аас доошгүйг шийдвэрлэх, 250 цагийн хууль зүйн зөвлөгөөг 200 хүнд өгөх.
 3. **Шадар сайд:** Төрийн худалдан авах ажиллагааны газрын төсөв Төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагддаггүй боловч төсөв, гүйцэтгэл нь сайдын багцад тайлагнадаг.
 4. **Төрийн албаны зөвлөл:** Шалгуур үзүүлэлтийн 1 зорилтот түвшинд 2 өөр мэдээлэл хамтад нь баталсан. Мөн тоон болон хувиар биш өгүүлбэрээр баталсан нь хүрсэн түвшний гүйцэтгэлийг гаргахад хүндрэлтэй. 20 төрийн байгууллага, 500 албан хаагч
 5. **Үндсэн хуулийн цэцийн дарга:** Шалгуур үзүүлэлтийн суурь түвшин болон зорилтот түвшин дээр өгүүлбэрээр буюу Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх гэж баталсан нь хүрсэн түвшний гүйцэтгэлийн хувийг тайлагнах боломжгүй.
 6. **ЗГХЭГ:** Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар Төсвийн хуулиар батлагдаагүй ч сайдын багцад тайлагнадаг. Мөн Хөтөлбөртэй байх шаардлагагүй. Зөвхөн ажлын албадын урсгал зардлууд тусч батлагдсан. ТЕЗ-ийн 2023 оны төсвийн төсөлд тусгагдаагүй МУС, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны ажлын алба, МУС, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны ажлын алба, МУС, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албадын төсөв сайдын багцад тайлагнасан. Зорилтот түвшний шалгуур үзүүлэлт өгүүлбэрээр батлагдсан. Жнь: Төлөвлөсөн хугацаанд 100 хувь хийгдсэн байх, MNS-ISO 9001:2016 стандартад нийцэж ажилласан.
 7. **Гадаад харилцааны сайд:** Зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг тоон утгаар илэрхийлээгүй. Жнь: суурь түвшнээс бууруулахгүй байх.
 8. **Сангийн сайд:** Зорилтот түвшний шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг тоон утгаар илэрхийлээгүй. Жнь: Хуульд заасан хугацаа, төсвийн тусгай шаардлагад нийцсэн байх. / Алдагдалтай буюу "Х" тайлан тушаалтын бууралтын хувь 0.06-1 гэж баталсан нь гүйцэтгэл гаргах тооцоолол систем дээр шийдэх үү. /
 9. **Хууль зүйн сайд:** ТТХ-ийн хавсралтаар батлагдсан боловч Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн төсөв, гүйцэтгэл гүйцэтгэл үр дүнгийн байгууллага учир төсвийн гүйцэтгэлд тайлагнаагүй.
-

БҮРЭЛДЭХҮҮН. ГУРАВ

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧДЫН ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНД
ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**


Төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагч нарын 2023 онд хэрэгжүүлэх 442 хөтөлбөр, 553 хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийт 628 чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тогтоолоор баталсан. Тайлант хугацаанд 63 хөтөлбөрийн 66 үр дүн нь 85% хүртэл гүйцэтгэлтэй, 327 хөтөлбөрийн 428 үр дүн нь 85%-100%-ийн гүйцэтгэлтэй, 52 хөтөлбөрийн 59 үр дүн нь 100%-с дээш гүйцэтгэлтэй байна.



Зураг 6 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн үзүүлэлт

Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 5.240.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 81 хувь буюу 4,336.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй. Үүнээс 85 болон түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй 379 хөтөлбөрт нийт 3,930.1 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 3,433.3 тэрбум төгрөг зарцуулагдсан буюу 87 болон түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байна.

ХӨТӨЛБӨР



Зураг 7 Орон нутгийн төсвийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн тоо

Орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт нийт 442 хөтөлбөр батлагдсанаас давхардаагүй тоогоор 72 хөтөлбөрт хуваарилагдсан байна. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчид нь улсын төсөвтэй харьцуулахад олон тооны хөтөлбөртэй, түүний дагуу төсөв нь хуваарилагддаг онцлогтой. Бүх төсвийн ерөнхийлөн захирагч 10-аас дээш тооны хөтөлбөртэй бөгөө үүнээс 13 төсвийн ерөнхийлөн захирагч нь 20 ба түүнээс дээш тооны хөтөлбөртэй байна. Хамгийн цөөн хөтөлбөртэй аймаг Хэнтий аймаг 12 хөтөлбөртэй, хамгийн олон хөтөлбөртэй аймаг нь Дархан-Уул аймаг 26 хөтөлбөртэй. Үүнд аймгууд хөтөлбөрөө батлахдаа бодлого чиг үүрэг болон төсвийн хуваарилагдсан хөтөлбөрийг баримтлах ялгаатай зарчмуудыг баримталж байгаагаас хөтөлбөрийн ялгаатай байдал үүсэхэд нөлөөлж байна. Орон нутгийн төсвийн хөтөлбөр, тэдгээрийн хүрэх үр дүнг ялгаатай байдлаар төлөвлөж, хэрэгжүүлж байгаа нь орон нутгийн

ялгаатай байдлыг бий болгож буй бус төсвийн үр дүнг төлөвлөх арга зүйг ашиглахгүй байх, хөтөлбөр үр дүнгийн ач холбогдлыг тооцохгүй байх, тогтвортой удирдлагыг хэрэгжүүлэхгүй байгаагаар шууд холбоотой байна. (Хавсралт № 5) Орон нутгийн 2023 оны төсөвт батлагдсан нийт 72 хөтөлбөрийг аймгуудад хэрхэн хуваарилагдсан байдлыг авч үзвэл:


1. Нийт 3 хөтөлбөр (орон нутгийн гүйцэтгэх засаглалыг хэрэгжүүлэх, нийгмийн халамж, Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа) нэг аймагт 2-оос дээш удаа ашиглагдсан байна. Энэ нь тухайн аймгууд төсвийн хавсралтыг бэлтгэх явцдаа харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнг нэгтгэх бус тус тусад нь мөр болгон давтаж оруулж байгаагаар холбоотой бөгөөд цаашид нэг аймаг нэг хөтөлбөртэй хамаарах хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагааг нэгтгэн боловсруулж баталж байх шаардлагатай юм.
2. Бүх аймаг, нийслэлд зарцуулах төсвийн эх үүсвэртэй бөгөөд хуулийн дагуу⁷ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаар төлөөлөх хэрэгжүүлэх нийтлэг байдаг хөтөлбөрүүд зарим аймгуудад дутуу батлагдаж байна. Энэ нь мөн аймгийн хэмжээнд төсвийн үр дүнгийн хавсралтыг боловсруулах явцад мэдээлэл дутуу, хангалттай боловсруулалт, хяналт шинжилгээ хийхгүй байгаагаар холбоотой юм. Жишээлбэл: Ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, мэргэжлийн боловсрол, соёл урлаг, биеийн тамир спорт, эмнэлгийн тусламж үйлчилгээ, насан туршийн боловсрол зэрэг хөтөлбөрүүд нь хэд хэдэн аймгуудад ялгаатай байдлаар дутуу батлагдсан. Жилийн эцэст төсвийн гүйцэтгэл, түүний хөтөлбөр, арга хэмжээний тайланг боловсруулахад эдгээр хөтөлбөрүүдэд бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарт төсөв хуваарилагдсан байдаг учраас хүрэх үр дүнгүй, хэмжих боломжгүй зэрэг хүндрэлүүд бий болдог байна.
3. Орон нутгийн төсвийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээг тодорхойлоход төвөгтэй бөгөөд аймгууд ялгаатай байдал үүсгэж байгаа төсөв бол хөрөнгө оруулалтын төсөвлөлт байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээ нь төсөл арга хэмжээгээр тухайн аймгийн хэрэгжүүлж байгаа аль нэг хөтөлбөрт хуваарилагдах боломжтой боловч нэгдсэн аргачлал байхгүй, төсөв хэлэлцэж батлах хугацаа бага тул боловсруулалт хийхэд хүндрэл учирдаг байна. Иймд зарим аймгууд хөрөнгө оруулалтын төсвийг “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт”, “Зорилтот хөрөнгө оруулалт”, “Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт”, “Ангилалдаагүй бусад” гэж ялгаатай байдлаар нэршиж баталсан байна. Иймд цаашид хөрөнгө оруулалтын төсвийн

⁷ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 27 дугаар зүйл.Нэгжийн удирдлагаар төлөөлөн гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг

хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлтөд хэрхэн тооцож оруулах талаар нэгдсэн зарчим, арга зүйтэй болох шаардлагатай байна.

- Орон нутгийн 2023 оны жилийн эцсийн хөтөлбөр, арга хэмжээний тайланд зөвхөн нэг аймагт ашиглагдсан нийт 36 хөтөлбөр байгаа бөгөөд энэ нь нийт хөтөлбөрийн 50 хувь нь буюу тал нь байна. Үүнд хэд хэдэн шалтгаанууд байгаа бөгөөд хамгийн түгээмэл нэг шалтгаан бол аймгууд хөтөлбөрийн нэрийг ялгаатай байдлаар нэрших, товчлох, өөрсдөө өөрчлөн найруулах, үг, нэр дутуу орхих техникийн алдаа зэрэг хууль эрх зүйгээр баталгаажсан нэршил ашиглахгүй байхгүй, төрийн байгууллагын албаны бичиг баримтын стандарт мөрдөхгүй зэрэгтэй уялдаатай боловсруулалт, хяналт дутуугаас шалтгаалж байна. Жишээлбэл: бичиг хэргийн стандартын хувьд алдаатай “Гадаадын зээл тусла-р хэр-х ТХ”, “Төрийн нийтлэг бусад үйлч СШин”, хөтөлбөрийн албан ёсны нэрийг ашиглахгүй товчилсон болон өөрчлөн найруулсан нэрс ашиглаж байгаа “Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид”, “Цагдаа” зэрэг хөтөлбөрийн нэр бус тухайн үйл ажиллагаа чиглэсэн товч нэрийг ашиглаж байна. Иймд орон нутгийн ялгаатай хөгжил, үйл ажиллагаатай холбоотой бус нийтлэг чиг үүргийн хөтөлбөрийн жишиг нэршил, хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлтийн жишгийг бий болгох шаардлагатай.

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН



Зураг 8 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тоо

Орон нутгийн төсвийн 22 ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт нийт 553 хөтөлбөрийн хүрэх үр дүн батлагдсан. Нэг төсвийн ерөнхийлөн захирагч дунджаар 2 хөтөлбөрийн үр дүнтэй байгаа бол нийт 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн 15 нь 20-оос дээш тооны хөтөлбөрийн хүрэх үр 2023 онд баталсан байна.

Хамгийн олон хөтөлбөрийн хүрэх үр дүн баталсан аймаг Өвөрхангай аймаг 46 хөтөлбөрийн үр дүнтэй бол хамгийн цөөн нь 16 буюу Говь-Алтай аймаг байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжийн дагуу хөтөлбөрийн хүрэх үр дүнд тавьсан шаардлагын хүрээнд нийт жилийн эцсийн тайлангийн хүрээнд судалж үзлээ.

Хүрэх үр дүнг “Тухайн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөсөн өөрчлөлтийг хэмжиж болохуйц үр дүн байдлаар бичнэ. Нэг хөтөлбөрийн хүрээнд хэд хэдэн үр дүнд хүрэхээр тодорхойлж болно” гэж заасан бөгөөд тодорхойлох хүрээнд⁸:

1. Салбарын эсвэл эрхлэх ажлын хүрээнд тулгарч байгаа асуудлыг шийдэх стратегийн зорилтыг агуулах, товч

тодорхой, нэг утгыг илэрхийлэх;

2. Тодорхой шийдвэр гаргахад чухал мэдээллийг илэрхийлэх;

3. Гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч ажилтан, албан хаагч тус үзүүлэлтийг тодорхойлоход оролцсон байх, тэдний саналыг тусгах;

4. Зөвхөн ач холбогдолтой гол үр дүнг тодорхойлох (зөвхөн хэмжиж болох үзүүлэлтүүд, хийх ажил эсвэл процессыг тоочихгүй байх) зэрэг шаардлагыг тавьсан бөгөөд үүнийг хөтөлбөр тус бүрийн хүрээнд нарийвчилсан судалгаа хийж дүгнэлт хийх шаардлагатай юм.

⁸ Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. ТМ-01а маягт бөглөх заавар. Эх сурвалж: Сангийн яам www.mof.gov.mn

Хүрэх үр дүнг тодорхойлох талаар дараах 4 үндсэн зарчим баримтлахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвлөмж болгосон бөгөөд тус зөвлөмжийн хүрээнд нийт 553 хөтөлбөрийг дараах байдлаар үнэллээ.

Зарчим	Хангасан	Эзлэх хувь
Хаана хэрэгжих (байршил)	51	9%
өөрчлөлтийг хэн хүртэх (үр шим хүртэгч, оролцогч тал)	187	34%
юуг өөрчлөхөөр зорьж байгааг,	339	61%
хүлээгдэж буй өөрчлөлтийн чиглэл (нэмэгдүүлэх/бууруулах)	408	74%


Нийт 553 үзүүлэлтийн шаардлагыг хангасан эсэхийг тооцоход “юуг өөрчлөхөөр зорьсон” үзүүлэлт хангалттай хангагдсан буюу 61 хувь байна. Энэ нь хөтөлбөрийн үр дүнд тухайн хөтөлбөрийг гол хэмжих зүйл болон хүчин зүйлийг дурдсан тул шаардлага хангаж байна. Харин бусад үзүүлэлтүүд улсын төсвийн нэгэн адил хангалтгүй байгаа бөгөөд “товч тодорхой” байх зарчим ч мөн хангагдахгүй байна. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөрийн хүрэх үр дүн нь цаашид сайжруулах шаардлагатай дараах нийтлэг алдаанууд байна. Үүнд:

1. Хөтөлбөрийн нэр, хөтөлбөрийн хүрэх үр дүн адилхан байх.
2. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүнд төсөл арга хэмжээний тоог бичих
3. “Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байх”, “Санхүүжилт хийсэн байх”, “Хууль тогтоомжид нийцсэн байх” гэх мэт ерөнхий, хүрэх үр дүн тодорхойгүй байдлаар томъёолох.
4. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн уялдаагүй байх. Жишээлбэл: “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх” хөтөлбөрийн хүрэх үр дүн “Төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлэх”, “Цагдаа” хөтөлбөрийн хүрэх үр дүн нь “Нийтийн тээврийн үйлчилгээг хянах” гэх мэт.
5. Хөтөлбөрийг хэт ерөнхий байдлаар томъёолсноос шалтгаалсан нэг хөтөлбөрийн хүрэх үр дүн хэт олон байх. Үүнд хорь ба түүнээс дээш хүрэх үр дүнтэй 19 аймгийн нийт 22 хөтөлбөр байна.

Иймд цаашид хөтөлбөрийн үр дүнг төлөвлөхдөө удирдамжийн зарчим, шаардлагыг хатуу мөрдөх, түүнийг хянаж шалгаж, нэгтгэх шаардлагатай байна.

ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2023 оны батлагдсан төсвийн дагуу орон нутгийн төсвийн нийт 22 төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад нийт 5.2 их наяд төгрөг батлагдсан бөгөөд жилийн эцэст 4.3 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 83 хувийн гүйцэтгэлтэй санхүүжсэн байна. Үүнд: нийт 7 аймгийн төсвийн гүйцэтгэл 90 буюу түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй байгаа бол нэг аймгийн төсвийн гүйцэтгэл 75 хувьтай буюу хамгийн бага гарсан байна. Энэ нь цаашид эдгээр төсвийн хөтөлбөрүүдийн үр дүнтэй болон үр ашигтай хэрэгжсэн байх нөхцөлийг бүрдүүлэх юм.




Зураг 9 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /аймгаар, тэрбум төгрөгөөр/

Нийт 72 хөтөлбөрийн төсвийн гүйцэтгэлээр ангилж үзэхэд 12 хөтөлбөр буюу 17 хувь нь 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Эдгээр бүрэн санхүүжиж хэрэгжсэн хөтөлбөрт оногдох нийт төсвийн гүйцэтгэл нь 19.0 тэрбум буюу нийт төсвийн 16 хувь оногдож байна. Гүйцэтгэл багатай буюу 50 хувиас бага гүйцэтгэлтэй 6 хөтөлбөр⁹, 80 хувиас бага гүйцэтгэлтэй 21 хөтөлбөр байна. Бага гүйцэтгэлтэй 14 хөтөлбөрт ногдох төсвийн гүйцэтгэл нь 1.0 их наяд буюу 6 хувь байна.

Нийт 72 хөтөлбөрөөс “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, үйл ажиллагаа” хөтөлбөр нь бүх аймаг, нийслэлд байдаг төрийн удирдлагыг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааны зардал болон зарим аймагт чиг үүргийг бүх төсвийг хуваарилснаас шалтгаалан хамгийн их төсөвтэй ба нийт төсвийн 56 хувь буюу 2.7 тэрбум төгрөг хуваарилсан. Тус хөтөлбөрийн гүйцэтгэл 2.3 их наяд буюу 81 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Түүнчлэн 100.0 болон түүнээс дээш төсөвтэй 5 хөтөлбөр байгаа бөгөөд (Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр, Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа, Цагдаа, Хот байгуулалт, тохижилт, Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт) зэрэг бүх аймаг нийслэлд түгээмэл байгаа хөтөлбөрүүд багтаж байна. Орон нутгийн 2023 оны жилийн эцсийн тайлангаар хөрөнгө оруулалтад хамаарах 3 хөтөлбөрт нийт 1.0 их наяд төгрөг хуваарилагдсан бөгөөд цаашид энэхүү хөрөнгө оруулалтын үр ашигт хамаарах хөтөлбөр, үр дүнтэй уялдуулж төлөвлөж тайлагнах нь илүү бодитой болох юм.


⁹ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Малыг эрсдлээс хамгаалах сан, Гадаадын зээл тусла-р хэр-х ТХ, Нийтийн тээврийн үйлчилгээ, Агаарын бхирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Хоршоо хөгжүүлэх сан




Зураг 10 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсөв, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь /хөтөлбөрөөр, сая төгрөгөөр/

ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ


Улсын төсвийн нийт 22 төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөрт нийт 628 шалгуур үзүүлэлт батлагдсан.



Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд шалгуур үзүүлэлтийн тоо харьцангуй ялгаатай байгаа бөгөөд 17-65 шалгуур үзүүлэлттэй байна. Хамгийн олон буюу 65 шалгуур үзүүлэлттэй аймаг Ховд аймаг, хамгийн цөөн буюу 17 шалгуур үзүүлэлттэй аймаг нь Төв аймаг байна. Хөтөлбөр, болон хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн судалгаатай харьцуулахад шалгуур үзүүлэлтийн харьцуулалт ялгаатай байгаа нь хөтөлбөр, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт нь хоорондоо уялдаа багатай байгааг мөн харуулж байна.



Нийт 628 шалгуур үзүүлэлтийн 421 нь буюу 67 хувь нь чанарын, 209 буюу 33 хувь нь тоон шалгуур үзүүлэлт батлагдсан байна. Харин нийт шалгуур үзүүлэлтийн 96 хувь буюу 609 нь өсөх хандлагатай



төлөвлөгдсөн.

Монгол Улсын 2023 оны төсвийн төслийн удирдамжид¹⁰ заасны дагуу үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг “төсвийн хөтөлбөрийн үр дүнг хоёроос доошгүй, таваас ихгүй тоон эсвэл чанарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр хэмжинэ” гэж заасан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн давхардаагүй тоогоор 427 хөтөлбөрийг харьцуулахад нийт 417 хөтөлбөр тус бүр 1 шалгуур үзүүлэлттэй, 9 хөтөлбөр 2 шалгуур үзүүлэлттэй, 1 хөтөлбөр 3 шалгуур үзүүлэлттэй ба удирдамжид заасан шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлтийн тоо хэдий цөөхөн байгаа нь нэг талаар оновчтой байх ёстой боловч орон нутгийн хувьд шалгуур үзүүлэлтийг хэт ерөнхий байдлаар хөтөлбөр, хүрэх үр дүнтэй ижил байдлаар тогтоох нь түгээмэл байна. Жишээлбэл: зарим аймгууд “бүрэн санхүүжсэн байна”, “зардал төлөгдсөн байна”, “гүйцэтгэлийн хувь”, “Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн санхүүжүүлэх”, “хамрагдсан байгууллагын санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулалтын хувь” гэх мэт шууд санхүүжилттэй уялдуулах, “хэвийн үйл ажиллагааг хангасан байх”, “Үйл ажиллагааны хэвийн, жигд байдал” гэх мэт тухайн хөтөлбөрт хамаарах байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах зэрэг нийтлэг байдал, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох талаар боловсруулалт хийхгүй, нэг аймгийн бүх хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт “Хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлсэн байна” гэж тогтоосон нь зарчим удирдамж баримтлахгүй байх гэх мэт дутагдалтай талууд байна.

Орон нутгийн төсвийн хөтөлбөр, арга хэмжээний тайлан нэгтгэхэд гарсан зарим хүндрэлийн жишээнээс:

1. Нийтлэг аймгуудын хувьд Төсвийн тухай хуулийн дагуу цаг хугацаанд тайлангаа багтааж өгөхдөө хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн тайлан нэгтгэн боловсруулахад 1-2 хоногийн нэмэлт хугацааг зарцуулж байсан. Энэ нь орон нутагт төрийн байгууллага, албан хаагчдын ажлын уялдаа болон тогтвортой байдалтай шууд холбоотой бөгөөд бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээний болон бусад холбогдох чиг үүргийн байгууллагууд хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн талаар ойлголт, оролцоо бага, ач холбогдол өгөхгүй байна.
2. Сангийн сайдын 2023 оны 255 дугаар баталсан тушаалын хэрэгжилт хангалтгүй бөгөөд тайланг албажуулах ажлыг Сангийн яаманд нэгтгэхээс өмнө хийж ирэхгүй байх, тайлангийн хуулийн хугацаа дууссаны дараа ч албажуулах ажил үргэлжилж байсан. Иймд цаашид холбогдох тушаал шийдвэрийн олон нийтэд түгээх, таниулах үй ажиллагааг хийх шаардлага байна.
3. Орон нутгийн хувьд улсын төсвийн ерөнхийлөн захирагчдаас ялгаатай нь төсвийн нэг дүгээр хавсралт буюу хүрэх үр дүнгийн хавсралт хяналт, оролцоо сул байгаагаас хөтөлбөр, түүний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн боловсруулалт хангалтгүй байна. Иймээс тэдгээрийг техникийн болон уялдааны хувьд олон ялгаатай байдлаар тогтоосон нь цаашид үр дүнг хэмжих, тайлагнах боломжийг хязгаарлаж байсан.

¹⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамж. ТМ-01а маягт бөглөх заавар. Эх сурвалж: Сангийн яам www.mof.gov.mn

Санал, зөвлөмж

1. Улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын хөтөлбөр, шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг гаргахад ашиглах эх сурвалж, тоон мэдээлэл тодорхойгүй, хариуцах албан хаагч, байгууллага ойлгомжгүй байх зэрэг нь хугацаа алдах, удаашрах шалтгаан болж байсан. Үүнд хөтөлбөр, арга хэмжээний тайлан нь тодорхой эрх зүйн баримт бичгээр баталгаажсан маягтын дагуу анхны удаа тайлагнаж байгаа нөлөөлсөн бөгөөд цаашид журмын дагуу төлөвлөж, тайлагнаж хэвшсэнээр сайжрах боломжтой.

2. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоогүй ихэвчлэн арга хэмжээний түвшинд шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Өөрөөр хэлбэр тухайн хөтөлбөр хэрэгжүүлээд гарах үр дүн бус төсвийг зарцуулсан байгууллагын үйл ажиллагааны явцаар хүрэх түвшинг төлөвлөсөн нь эргээд тайлагнахад тухайн хөтөлбөрийн үр ашгийг бүрэн тодорхойлох боломжгүйд хүргэж байсан. Жишээ 1 нь: Үйл ажиллагаагаар: “Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг 5 удаа зохион байгуулах”. Жишээ 2: Шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц биш ихэвчлэн өгүүлбэрээр баталсан. “Орон нутгийн гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагааны хэвийн, жигд байдал хангагдсан”. Жишээ 3. нийтлэг төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр зорилтын хэрэгжилтийг хангах, тэд- ээс доошгүй гэх мэт шалгуур үзүүлэлт баталсан нь гүйцэтгэл, үр дүн тооцоход хүндрэлтэй байсан. “Хурлын хуралдааныг улиралд 1-с доошгүй, удаа хуралдуулж шийдвэр гаргана.”

3. Цаашид төлөвлөлт, төсөвлөлтийн бүх үе шатанд үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчим, шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлага, хөтөлбөр, арга хэмжээний тайлангийн холбогдох журамд заасан шалгуур, эх сурвалжийн баталгаажуулалт зэргийг сайжруулснаар тайлагналын явцын болон эцсийн үр дүн бодитой, найдвартай, хэмжигдэхүйц, шуурхай болох боломжтой болно.

Хавсралт

Хавсралт № 1 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын 2023 оны хөтөлбөр, арга хэмжээний тоон үзүүлэлт

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ХӨТӨЛБӨРИЙН ТОО	ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТОО	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР	1	4	4
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД	8	10	12
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	2	5	8
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	1	1	1
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	8	9	29
ГАДААД ХЭРГИЙН САЙД	2	2	5
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР	2	3	5
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	4	4	16
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР	3	3	3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1	3	3
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	3	9	9
МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	1	1	2
МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	1	1	2
МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	1	2	2
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	4	4	13
САНГИЙН САЙД	3	3	10
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО	1	4	4
СОЁЛЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	1	1	8
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО	1	3	3
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ	2	2	6
УЛСЫН ДЭЭД ШҮҮХ	1	1	3
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	1	3	3
УЛСЫН ИХ ХУРАЛ	1	1	3
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	1	14	14
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ	1	1	3
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ	1	2	2
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО	1	3	8
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	6	10	19
ХУУЛЬ ЗҮЙН САЙД	13	16	48
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС	1	1	3
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	6	8	14
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС	1	2	4
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	1	1	5

ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	2	3	3
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1	1	1
ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО	1	1	1
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	5	6	16
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	2	5	5
Нийт	96	153	300

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ	ХӨТӨЛБӨР ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ	ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛ	ҮР АШИГ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР	97%	100%	100%	3%
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД	90%	65%	64%	-24%
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	111%	148%	198%	87%
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	96%	100%	100%	4%
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	95%	99%	98%	3%
ГАДААД ХЭРГИЙН САЙД	69%	212%	168%	99%
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР	89%	100%	100%	11%
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	99%	757%	941%	841%
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР	78%	100%	100%	4%
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	99%	71%	71%	-28%
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	97%	96%	64%	-33%
МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	65%	173%	173%	108%
МОНГОЛ УЛСЫН САЙД, НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	72%	53%	53%	-20%
МОНГОЛ УЛСЫН САЙД, ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	97%	113%	113%	16%
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	98%	120%	88%	-11%
САНГИЙН САЙД	95%	97%	98%	-1%
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО	73%	142%	142%	69%
СОЁЛЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	98%	127%	127%	28%
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО	70%	187%	188%	118%
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ	95%	112%	129%	34%
УЛСЫН ДЭЭД ШҮҮХ	87%	118%	118%	31%
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	96%	103%	103%	7%
УЛСЫН ИХ ХУРАЛ	99%	208%	208%	109%
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	93%	80%	80%	-13%
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ	100%	100%	100%	0%
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ	70%	99%	99%	29%
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО	96%	167%	167%	71%
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	88%	96%	60%	-27%
ХУУЛЬ ЗҮЙН САЙД	100%	237%	148%	56%
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС	99%	265%	264%	165%
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	92%	73%	62%	-35%

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИСС	100%	94%	94%	-6%
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	87%	97%	97%	10%
ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	85%	80%	60%	-25%
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	97%	103%	103%	6%
ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО	97%	95%	95%	-2%
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	99%	102%	109%	10%
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	100%	115%	112%	12%
Дундаж	93%	165%	145%	52%

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ХӨТӨЛБӨРИЙН ТОО	ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТОО	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОО
Архангай	18	18	18
Баян-Өлгий	16	18	26
Баянхонгор	19	21	26
Булган	25	26	42
Говь-Алтай	16	16	21
Дорноговь	19	19	19
Дорнод	21	21	21
Дундговь	21	21	21
Завхан	21	24	24
Өвөрхангай	21	46	46
Өмнөговь	21	29	29
Сүхбаатар	14	18	28
Сэлэнгэ	23	28	30
Төв	17	17	17
Увс	22	22	36
Ховд	22	42	65
Хөвсгөл	24	24	37
Хэнтий	12	28	25
Дархан-Уул	26	39	39
Нийслэл	19	19	19
Орхон	24	36	36
Говьсүмбэр	21	21	22
Нийт	442	553	647

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ	ХӨТӨЛБӨР ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ	ХӨТӨЛБӨРИЙН ГҮЙЦЭТГЭЛ	ҮР АШИГ
Архангай	89%	91%	91%	2%
Баян-Өлгий	89%	92%	94%	5%
Баянхонгор	90%	90%	98%	7%
Булган	89%	113%	117%	28%
Говь-Алтай	91%	94%	95%	4%
Дорноговь	86%	100%	100%	14%
Дорнод	90%	97%	97%	7%
Дундговь	95%	99%	99%	4%
Завхан	89%	90%	87%	-2%
Өвөрхангай	91%	97%	96%	5%
Өмнөговь	83%	103%	104%	25%
Сүхбаатар	85%	106%	101%	23%
Сэлэнгэ	86%	90%	92%	6%
Төв	91%	101%	101%	9%
Увс	90%	94%	96%	6%
Ховд	86%	136%	119%	34%
Хөвсгөл	89%	93%	90%	0%
Хэнтий	75%	89%	74%	-1%
Дархан-Уул	81%	94%	94%	13%
Нийслэл	80%	104%	104%	0%
Орхон	89%	99%	99%	10%
Говьсүмбэр	87%	99%	99%	12%
Дундаж	87%	101%	98%	10%

Хавсралт № 5 Орон нутгийн төсвийн ерөнхийлөгчдийн 2023 оны хөтөлбөрийн нэрс, аймгуудад ашиглагдсан байдал давтагдсан тоогоор

Дд	Хөтөлбөрийн нэр	Давтагдсан тоо /аймгаар/
1	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	1
2	Мал аж ахуйг хөгжүүлэх	1
3	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	1
4	Соёл урлаг	1
5	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1
6	Ангилалдаагүй бусад	1
7	Ариун цэврийн байгууламж	1
8	Батлан хамгаалах судалгаа шинж	1
9	Гадаадын зээл тусла-р хэр-х ТХ	1
10	Газрын баталгаажуулалт	1
11	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	1
12	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	1
13	Дотоод аудит, эрсдэлийн удирдлага	1
14	Замын сан	1
15	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид	1
16	Малыг эрсдэлээс хамгаалах сан	1
17	Мэдээллийн нэгдсэн тогтол дэд	1
18	Нийтийн тээврийн үйлчилгээ	1
19	Орон нутгийн зам	1
20	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	1
21	Орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг	1
22	Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага	1
23	Санхүүгийн зөрчил буурч, төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хариуцлага сайжирна.	1
24	Стандартчилал, хэмжил зүй	1
25	Төрийн нийтлэг бусад үйлч СШин	1
26	Тусгай хэрэгцээт боловсрол	1
27	Ус сувгийн татаас	1
28	Хог хаягдал	1
29	Хоршоо хөгжүүлэх сан	1
30	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил хамгаалал	1
31	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	1
32	Худалдан авах ажиллагаа	1
33	Хүүхдийн хөгжил, хамгаалал	1
34	Цаг агаарт зориудаар нөлөөлөх	1
35	Цагдаа	1
36	Эрүүл мэнд	1
37	Ойжуулалт	2
38	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	2
39	БХБНААхуйн бодлого удирдлага	2
40	Зорилтот хөрөнгө оруулалт	2

41	Засгийн газрын өрийн үйлчилгээ	3
42	Орон нутгийн хөгжлийн сан	3
43	Орон нутгийн хэвлэл, мэдээллийн үйл ажиллагаа	3
44	Сургуулийн өмнөх боловсрол	4
45	Мэргэжлийн хяналт	4
46	Орон нутгийн төсөвт байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах	4
47	Хөдөө аж ахуй, газар тариалан бодлого	4
48	Авто тээврийн хяналт, зохицуулалт, үйлчилгээ, нийтийн тээвэр	5
49	Гамшгаас урьдчилан сэргийлэх	5
50	Насан туршийн боловсрол	5
51	Суурин газрын усан хангамж	8
52	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	11
53	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	11
54	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	11
55	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	12
56	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	13
57	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	14
58	Мал аж ахуйг хөгжүүлэх	14
59	Ахмад настны хөгжил, хамгаалал	15
60	Сургуулийн өмнөх боловсрол	15
61	Хот байгуулалт, тохижилт	15
62	Ойжуулалт	16
63	Автозам	17
64	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	17
65	Мэргэжлийн боловсрол	18
66	Соёл урлаг	18
67	Биеийн тамир спорт	19
68	Ерөнхий боловсрол	19
69	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	21
70	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	23
71	Нийгмийн халамж	24
72	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, үйл ажиллагаа	27